



ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ИНВЕСКОР ЭЙ БИ ЭС ТЗК” ХХК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛСОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: СТА/ААНБ-2025/06

Улаанбаатар хот
2025 он

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

“Лидер экаунт аудит” ХХК

Утас: 88112654, 88472789

Цахим хаяг: leaderaudit.20@gmail.com

АГУУЛГА

ХУУДАС

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН	3 – 4
1. Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан	5
2. Аудитлагдсан орлогын дэлгэрэнгүй тайлан	6
3. Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан	7
4. Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан	8
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9 – 16
1. Компанийн талаархи мэдээлэл	9 – 10
2. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд	11 – 17
3. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт	18 – 22



“ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ” ХХК

2025 оны 3 сарын 28 өдөр

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Парисын гудамж - Ай Си Тауэр, 6 давхар 607 тоот
Утас: 88472789, 88112654
И-мэйл: leaderaudit.20@gmail.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ИНВЕСКОР ЭЙ БИ ЭС ТЗК ХХК-ИЙН УДИРДЛАГАД

Дүгнэлт

Бид “Инвескор Эй Би Эс ТЗК ХХК”-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “Инвескор Эй Би Эс ТЗК ХХК” 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын сандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Аудитын явцад бидний олж авсан баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шудрага бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг, хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт (АДБОУС)-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулагад санал өгөх хангалттай зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 95.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох “Инвескор Эй Би Эс ТЗК ХХК”-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Лидер экаунт аудит ХХК-ийн
Захирал П.Наравхорол

2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр
Улаанбаатар хот

1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ИНВЕСКОР ЭЙ БИЭС ТЗК ХХК-ИЙН
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
(2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

		(төгрөгөөр)	
Үзүүлэлт	Тод	2024 оны 6-р сарын 31-ний үлдэгдэл	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрнгө	3.1	10,000,000.00	704,959,591.93
Дансны авлага	3.2	-	45,742,486,735.67
Бусад авлага	3.3	-	4,590,021,250.55
Эргэлтийн хөрөнгийн дүн		10,000,000.00	51,037,467,578.15
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		10,000,000.00	51,037,467,578.15
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Татварын өр	3.4	-	224,918,036.14
Хүүний өглөг	3.5	-	628,754,523.29
Бусад богино хугацаат өр төлбөр	3.6	-	24,231,986,666.67
Богино хугацаат өр төлбөрийн дүн		-	25,085,659,226.10
Урт хугацаат өр төлбөр			
Бусад урт хугацаат өр төлбөр	3.7	-	24,871,997,777.67
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	24,871,997,777.67
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		-	49,957,657,003.77
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Хувьцаат капиталын дүн	3.8	10,000,000.00	10,000,000.00
Хуримтлагдсан ашиг/алдагдал		-	1,069,810,574.38
Эзэмшигчдийн өмчийн дүн		10,000,000.00	1,079,810,574.38
НИЙТ ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН		10,000,000.00	51,037,467,578.15

*Энэхүү санхүүгийн тайлангийн 9-22 дугаар хуудсан дах тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн сэтгэгдэл хэсэг болно.

2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

ИНВЕСКОР ЭЙ БИ ЭС ТЗК ХХК-ИЙН АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

(төгрөгөөр)			
Үзүүлэлт	Тод	Өмнөх он	Тайлант он
Үйл ажиллагааны орлого		-	-
Хүүний орлого	3.9	-	5,185,332,236.97
Бусад орлого		-	-
Борлуулалт, маркетингийн зардал		-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	3.10	-	568,540,811.68
Санхүүгийн зардал	3.11	-	3,428,113,009.32
Бусад зардал		-	-
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ/АЛДАГДАЛ		-	1,188,678,415.97
Орлогын татварын зардал	3.12	-	118,867,841.59
ЦЭВЭР АШИГ		-	1,069,810,574.38
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
ТАЙЛАНТ ХУГАЦААНЫ НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ДҮН		-	1,069,810,574.38

*Энэхүү санхүүгийн тайлангийн 9-22 дугаар хуудсан дах тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн сэтгэгдэл хэсэг болно.

3. Аудит хийсэн эздийн өмчийн өөрчлөлтийн тайлан

**ИНВЕСКОР ЭЙ БИ ЭС ТЗК ХХК-ИЙН
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
(2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)**

	(төгрөгөөр)		
Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2024 оны 6-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,000,000.00	-	10,000,000.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл	10,000,000.00	-	10,000,000.00
Тайлант үеийн цэвэр ашиг		1,069,810,574.38	1,069,810,574.38
Хуваарилсан ногдол ашиг	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,000,000.00	1,069,810,574.38	1,079,810,574.38

*Энэхүү санхүүгийн тайлангийн 9-22 дугаар хуудсан дах тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно.

4. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ИНВЕСКОР ЭЙ БИ ЭС ТЗК ХХК-ИЙН
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

	(төгрөгөөр)	
Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(2,193,469,695.70)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	-	-
Хүлээн авсан хүүний орлого	-	-
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	-	2,193,469,695.70
Ажиллагчдад төлсөн	-	3,007,036.44
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	877,664.40
Хүүний төлбөрт төлсөн	-	2,073,219,178.05
Татвар байгууллагад төлсөн	-	242,824.74
Зохицуулалтын хөлс, шимтгэл, хураамжинд төлсөн	-	1,000,000.00
Бусад мөнгөн зарлага	-	115,122,992.07
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(57,338,809,876.08)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого	-	-
Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага	-	57,338,809,876.08
Үндсэн ба биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	57,338,809,876.08
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	10,000,000.00	60,227,239,163.71
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	10,000,000.00	60,227,239,163.71
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	60,227,239,163.71
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,000,000.00	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	-	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	10,000,000.00	694,959,591.93
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	10,000,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,000,000.00	704,959,591.93

*Энэхүү санхүүгийн тайлангийн 9-22 дугаар хуудсан дах тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

1. КОМПАНИЙН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

1.1. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл

Бүртгэлийн дугаар:	9011863043
Регистрийн дугаар:	7008721
Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар:	ТЗ 315/67 (Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 288 дугаар тогтоол)
Компанийн нэр:	"Инвескор Эй Би Эс ТЗК" ХХК
Үүсгэн байгуулагдсан огноо:	2024.03.25
Үйл ажиллагаа:	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах /2024.06.10-/
Дүрмийн сан:	10,000.0 мянган төгрөг
Хувьцаа эзэмшигч:	"Инвескор ББСБ" ХК
Төлөөлөн удирдах зөвлөл:	ТУЗ-ийн дарга Д.Баясгалан ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Санжаасүрэн ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Хэрлэнчимэг
Компаний хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, парисын гудамж, Ай Си тауер, 14 давхар
Утас:	+(976) 7709 0099
Цахим шуудан:	Info@invescore.mn
Шуудангийн код:	14230

1.2. Оролцогч байгууллагууд

Үнэт цаас гаргагч:	"Инвескор Эй Би Эс ТЗК" ХХК
Анхны үүрэг гүйцэтгэгч:	"Инвескор ББСБ" ХК
Андеррайтер:	"Инвескор капитал ҮЦК" ХХК
Хуулийн зөвлөх:	"Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс" ХХК
Зээлийн шинжилгээ гаргагч:	"Си Пи Ти Эй Аудит" ХХК
Хөрөнгө итгэмжлэн удирдагч:	"Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК

1.3. Үнэт цаасны ерөнхий мэдээлэл

Үнэт цаас гаргагч:	"Инвескор Эй Би Эс ТЗК" ХХК
Анхны үүрэг гүйцэтгэгч:	"Инвескор ББСБ" ХК
Үнэт цаасны бүртгэл:	"Монголын Хөрөнгийн Бирж" ХК
Үнэт цаасны төрөл:	Автотээврийн хэрэгслийн фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ:	100,000.00 төгрөг
Үнэт цаасны тоо ширхэг:	500,000 ширхэг

Үнэт цаасны нийт үнийн дүн:	50,000,000,000.00 төгрөг
Үнэт цаасны хугацаа:	18 сар
Үнэт цаасны хүү:	17.0% /жилийн/
Үнэт цаасны хүү төлөх хуваарь:	Улирал тутам
Үнэт цаасны хүү тооцох суурь хоног:	365 хоног
Үнэт цаасны үндсэн төлбөр төлөх хуваарь:	Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш: 12 дахь сард үндсэн төлбөрийн 50% 18 дахь сард үндсэн төлбөрийн 50%
Үнэт цаасны хүүгийн орлогод ногдох албан татварын хэмжээ:	5.0%
Үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоо:	“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК
Хөрөнгийн багцын үнийн дүн:	49,981,757,007.93 төгрөг
Хөрөнгийн багц дах зээлийн тоо:	360
Хөрөнгийн багц дах зээлдэгчийн тоо:	360
Хөрөнгийн багцын чанар:	100% хэвийн зээл
Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журмууд:	- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам - Хөрөнгө итгэмжлэн удирдах журам - Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам - Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам - Хөндлөнгийн аудитор, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам - Мөнгө угаах, терроризмыг санхүүжилэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам - Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам - Тусгай зориулалтын компанийг татан буулгах журам
Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч талуудтай байгуулсан гэрээнүүд:	- Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ - Фидуцийн барьцааны гэрээ - Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ - Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ - Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ - Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

2.1. Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Компанийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу түүхэн өртгөөр бүртгэх тогтсон зарчмыг баримтлан бэлтгэгдсэн ба энэ зарчим нь бодит үнэ цэнээрх тодорхой санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн үнэлгээн дээр үндэслэн санхүүгийн анхлан хүлээн зөвшөөрөх өөрчлөлтийг тусгасан. Компани өөрийн санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадварын дарааллаар толилуулдаг. Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн хураангуйлсан үндсэн бодлогуудыг дор толилуулав. Өөрөөр заагаагүй санхүүгийн тайлагналын хугацааны туршид эдгээр бодлогыг тогтмол баримталдаг.

2.2. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, таамаглалууд

Компанийн санхүүгийн тайланг бэлтгэхийн тулд удирдлага нь санхүүгийн тайланд орлого ба зардал, хөрөнгө ба өр төлбөр, болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, холбогдох тодруулгуудыг бэлтгэхэд шаардлагатай үнэлэмж, таамаглал тооцооллуудыг хийдэг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг зөвхөн нөлөөлж байгаа тайлант үед эсхүл ирээдүйн болон одоогийн тайлант үеүдэд нөлөөлөх бол ирээдүйн болон одоогийн тайлант үеүдэд тус тус тусгадаг.

2.2.1. Тайлангийн мөнгөн тэмдэгт

Эдгээр санхүүгийн тайлангуудыг барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг эдийн засгийн анхдагч орчны мөнгөн тэмдэгт буюу үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлсэн.

2.2.2. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь дуусгавар хугацаа нь худалдан авч эзэмшсэнээс хойш 3 сар болон түүнээс богино хугацаагаар тодорхойлогдсон бөгөөд бодит үнэ цэнэ өөрчлөгдөхөд өчүүхэн төдий эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, компанийн удирдлага богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшиж буй бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ.

2.2.3. Бараа материал

Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлдог ба бараа материаллаг анх олж эзэмшсэн өртгөөр нь бүртгэлд тусгана. Байнгын системээр бараа материалын бүртгэлийг хөтөлж буй үед тайлант үеийн эцэс бүр бараа материалын бүртгэлээр тодорхойлсон дүн нь биет тооллогын дүнгээс зөрүүтэй байвал бараа материалын дүнд залруулах бичилт хийдэг. Хэрэв бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ нь анх олж эзэмшсэн өртгөөс бага тохиолдолд бараа материалын үнэ цэнийн бууралтын гарз үүсэх бөгөөд уг гарзыг тухайн тайлант хугацаанд үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Цэвэр боломжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад бараа материалыг худалдан борлуулахаар тооцоолж буй үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүн юм.

2.2.4. Урьдчилгаа төлбөр

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь хараахан гараагүй төлбөр эсвэл хүлээн аваагүй бараа материалын төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлбөрийг анх өртгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд эсвэл хугацаа дуусах үед ашиг, алдагдал руу болон бараа материалыг хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгөнд ангилдаг.

Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагдах бол урьдчилгаа төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

Тайлант жилийн эцэст компани урьдчилгаа төлбөрийн дансны үнэд хяналт тавьж, үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг тодорхойлдог.

2.2.5. Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрүүдийг компани тухайн хэрэглүүртэй холбоотой гэрээт тал болох үед нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэх ба үүнд гэрээт харилцагчдаас үүссэн дансны авлагыг СТОУС 9-ийн дагуу анх бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр/ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад/-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасаж бүртгэнэ.

Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг тухайн жилийн ашиг, алдагдлаар бүртгэнэ.

2.2.6. Санхүүгийн хөрөнгө

Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг.

Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцөлөөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.

Санхүүгийн хөрөнгийг ангиллаас нь хамааран анх бүртгэсний дараа хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр хэмждэг.

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүд нь дараа үеүдэд хордуулсан өртгөөр хэмжигдэнэ.

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой бизнесийн загвараар эзэмшдэг болон

- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх.

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүдийг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжинэ. /БДОБҮЦ/

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд эсвэл арилжаалах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий бизнесийн загвараар эзэмшдэг болон
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх.

Бусад бүх санхүүгийн хөрөнгийг дараа үед ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнэ /ААБҮЦ/-ээр хэмжинэ.

- Хорогдуулсан өртөг болон үр ашигт хүүгийн арга

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өртгийг тооцоолон хүүгийн орлогыг урт хугацааны туршид хуваарилах арга юм.

Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгөөс бусад /анхан хүлээн зөвшөөрөхдөө үнэ цэнэ нь буурсан хөрөнгө, санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр, үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан/-ийг санхүүгийн өрийн гэрээний хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн цэвэр дансны үнэтэй тэнцүү байхаар үнэ цэнийн бууралтын нөөцийг хасахын өмнөх төлбөрийг өрийн хугацаа эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хуваарилахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

Санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж анхны дүн ба дуусгавар болох үеийн дүнгийн хооронд үүссэн аливаа зөрүүг үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон хорогдуулгыг нэмж аливаа алдагдлын нөөцийг тохируулсан дүнгээр тодорхойлогдоно.

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь аливаа алдагдлын нөөцөөр тохируулаагүй дүн байна.

Хүүгийн орлогыг анх үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөр болон БДОБҮЦ-ээр хэмжигдэх бүх өрийн хэрэгслүүдийн хувьд бүртгэдэг. Зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хүүгийн орлогыг тухайн санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэд үр ашигт хүүгийн түвшинг ашиглах замаар тооцоолно.

Дараа тайлант үед зээлийн үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хувьд тухайн хөрөнгийн хорогдуулсан өртөг үр ашигт хүүгийн түвшин ашиглах замаар тодорхойлно. Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл дараа тайлант үед сайжирч

санхүүгийн хөрөнгө нь зээлийн үнэ цэнийн бууралтгүй болсон ч гэсэн тооцооллыг нийт сууриар буцаахгүй.

Хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар тайлагнадаг ба санхүүгийн орлого хэсэгт ангилна.

Компани нь зөвхөн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусвар болсон эсвэл санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх ба хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг бусдад шилжүүлсэн үед санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийг данснаас хасахдаа тухайн хөрөнгийн дансны үнэ ба хүлээн авсан дүн болон авлагын нийлбэрийн зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

2.2.7. Санхүүгийн өр төлбөр ба өмч

Гэрээний зохицуулалтын агуулга болон санхүүгийн өр төлбөр болон өмчийн хэрэгслийн тодорхойлолтын дагуу өр болон өмчийн хэрэгслийг санхүүгийн өр төлбөр эсвэл өмч гэж ангилдаг.

■ Өмчийн хэрэгсэл

Компанийн бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Группээс гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг.

■ Энгийн хувьцаа

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын аливаа нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

■ Хувьцаат капиталыг буцаан худалдан авах /халаасны хувьцаа/

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татварын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бүртгэл гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг.

Хувьцаат хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

■ Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг нь компанийн өмчийн эздэд ногдох ашгаас зарласан ногдол ашгийг хассан дүн болно. Стандартад шилжилтийн шаардлагын дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс үүссэн нөлөөллийг хуримтлагдсан ашиг бүртгэдэг.

- Эздийн оруулсан хөрөнгө оруулалт

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс өмнө болон бусад мөнгөн бус хөрөнгөөр сайн дурын үндсэн дээр оруулсан хөрөнгө оруулалт нь тухайн хөрөнгийн бодит үнэ цэнээр эздийн өмчид шууд бүртгэгддэг.

- Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц

Хөрвүүлэлтийн нөөц нь гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайлангийн хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү болон компанийн гадаадын охин компанид оруулсан цэвэр хөрөнгө оруулалтыг хийсэн өр төлбөрийн хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүнээс бүрдэнэ.

2.2.8. Санхүүгийн өр төлбөр

Бүх санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэсний дараа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Компанийн санхүүгийн өр төлбөр нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хэрэгслүүдээс бүрддэг.

- Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцож холбогдох хугацааны туршид хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр /үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан/-ийг санхүүгийн өр төлбөрийн хугацааны туршид эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хорогдуулахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

- Санхүүгийн өр төлбөрийг данснаас хасах

Компани нь санхүүгийн өр төлбөрийг гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд данснаас хасна. Данснаас хасаж буй санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба төлсөн дүн болон өглөгийн нийлбэрийн зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

2.2.9. Орлого хүлээн зөвшөөрөлт

Бараа борлуулсны орлого, хөрөнгөө бусдад ашиглуулсны болон үйлчилгээ үзүүлсний орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр нь хэмжих ба гарсан аливаа худалдаа, үйлчилгээний буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт зэргийг хассан цэвэр дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

- Үйлчилгээ үзүүлсний орлого

Үйлчилгээний орлогод гэрээгээр гүйцэтгэсэн үйлчилгээний орлого хамаарна. Эдгээр орлогууд нь үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө.

Үйлчилгээний орлогод гэрээгээр гүйцэтгэсэн үйлчилгээний орлого хамаарна. Эдгээр орлогууд нь үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө.

Үйлчилгээнээс орох орлогыг тухайн ажил гүйлгээний тайлагналын өдрөөрх гүйцэтгэлийн үйл явцтай нь уялдуулан ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үйлчилгээний гүйцэтгэлийн үйл явцыг гүйцэтгэсэн ажилд хийсэн судалгаанд үндэслэн үнэлдэг.

- **Бараа борлуулсаны орлого**

Компани барааны өмчлөлтэй холбогдон үүсэх мэдэгдэхүйц эрсдэл эсвэл өгөөжийг худалдан авагч талд шилжүүлсэн, борлуулсан барааныхаа өмчлөлд холбогдох аливаа удирдлагын болон хяналтын үүргийг өөртөө хадгалаагүй, орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой, тухайн ажил гүйлгээний эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд тухайн ажил гүйлгээтэй уялдаж гарсан ба цаашид гарах зардлыг найдвартай хэмжин тодорхойлж болохоор байгаа үед орлогыг хүлээн зөвшөөрдөг.

2.2.10. Гадаад валютаарх ажил гүйлгээ болон үлдэгдэл

Компанийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн тайлагналын валютаас бусад валютыг /гадаад өртөг/ ажил гүйлгээ гарсан өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэсэн.

Төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгт нь гадаад валют гэж тооцогддог ба гадаад валютаар хийгдсэн гүйлгээнүүдийг тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар төгрөг рүү хөрвүүлдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг санхүү байдлын тайлангийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө, хөрөнгө болон өр төлбөрүүдийн гүйлгээ хийгдсэн өдрөөс хойших ханшийн өөрчлөлтөөс үүсэн гарах өөрчлөлтийг гарсан цаг хугацаанд нь ашиг алдагдлаар бүртгэнэ.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн хөрөнгө ба өр төлбөрийг тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар хөрвүүлдэг. Ханшийн зөрүүнээс үүсэн зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусган эздийн өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэнэ.

2.2.11. Зардлын хүлээн зөвшөөрөлт

Зардлын орлогын дэлгэрэнгүй тайланд зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан барааны бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтана. Компанийн үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт ба маркетингийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

- **Санхүүгийн зардал**

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрдэх ба ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдсөн бүртгэлд тусгагддаг. Шалгуурт нийцсэн хөрөнгийн олж бэлтгэх, барьж байгуулах ба үйлдвэрлэхэд шууд холбоотой хүүгийн зардлыг тэдгээр хөрөнгийн өртөгт оруулж бүртгэдэг. Шалгуурт нийцсэн хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлэх ба уг хөрөнгийг ашиглах ба борлуулахад бэлэн болгох хүртэлх хугацаанд хүүгийн зардлыг хөрөнгийн өртөгт оруулдаг.

Зориулалт нь тодорхой зээлийг холбогдох хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж эхлэх хүртэл эсвэл борлуулахад бэлэн болсон нь тодорхой болсон үед зээлийн кадиталжуулалтын түвшинг тооцох зорилгоор зээлийн ерөнхий санд байлгадаг. Тодорхой зээлийг түр хугацаагаар хөрөнгө оруулалт хийх зорилгоор олж авсан хөрөнгө оруулалтын орлого нь шаардлага хангасан хөрөнгөнд зарцуулагдах хүртэл хүлээгдэж байна. Зээлийн хүүгийн зардлаас хасаж хөрөнгийн зориулалт нь тодорхой зээлээрх түр хөрөнгө оруулалтаас олсон хөрөнгө оруулалтын орлогын зарцуулалтыг зээлийн өртгөөс хасаж капиталжуулан хөрөнгийн өртөгт бүртгэнэ.

2.2.12. Орлогын татвар

Орлогын татварын зардал нь тайлант үеийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Орлогын татварын зардлыг өмчийн дансанд шууд хүлээн зөвшөөрдөг зүйлстэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Тайлант үеийн татвар гэдэг нь өмнөх жилүүдийн татварын өрийн тодруулга болон тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эсвэл мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээг ашиглан тухайн жилийн татвар ногдох ашиг, татварын алдагдалд суурилан хүлээгдэж буй татварын өр эсвэл авлага юм.

Татвар ногдох орлого бий болох нь тодорхой болсон бүх татвар ногдох түр зөрүүнд хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрдөг. Тайлант үеийн эцсээр хүчин төгөлдөр болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ /татварын хууль/-нд үндэслэн хөрөнгө нь хэрэгжиж буй өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварыг хэмждэг.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

3.1. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Банкин дах мөнгө		
Голомт банкн дах харилцах 8125102668 /MNT/	10,000,000.00	34,959,591.93
Голомт банкн дах хадгаламж 8125102840 /MNT/	-	670,000,000.00
Нийт дүн	10,000,000.00	704,959,591.93

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эцэст 705.0 сая төгрөг байгаагийн 35 сая төгрөг нь банкин дах харилцах дансны үлдэгдэл, 670 сая төгрөг нь банкин дах хадгаламжийн дансны үлдэгдэл байна. Харилцах дансны үлдэгдлийг банкны дансны гүйлгээ, үлдэгдлийн баталгааны хуудастай тулган шалгахад тохирч байна.

3.2. Дансны авлага

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Зээлийн багц – “Инвескор ББСБ” ХК	-	46,422,654,539.51
Эрсдэлийн сан	-	(680,167,803.84)
Нийт үлдэгдэл	-	45,742,486,735.67

Дансны авлагын эцсийн үлдэгдэл 45,742.5 сая төгрөг, үүний 46,422.7 сая төгрөг нь зээлийн багц, 680.2 сая төгрөгийг эрсдэлийн санд байршуулсан байна.

“Инвескор Эй Би Эс ТЗК” ХХК нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч “Инвескор ББСБ” ХК-тай 2024 оны 6 дугаар сарын 18-ны өдөр “Хөрөнгө худалдах, худалдан авах” 240618-01 дугаар бүхий гэрээний дагуу Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан шаардлагыг хангасан 70,684.8 сая төгрөгийн үлдэгдэл бүхий 491 зээлийн гэрээг багцлан авна гэж төлөвлөснөөс 49,981.8 сая төгрөгөөр 360 зээлийн гэрээг багцлан авсан байна.

3.3. Бусад авлага

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
“Инвескор ББСБ” ХК зээл	-	3,660,003,286.14
Хүүгийн авлага	-	930,017,964.41
Нийт дүн	-	4,590,021,250.55

Бусад авлага нийт 4,590.0 сая төгрөг, үүний дотор 3,660.0 сая төгрөг нь “Инвескор ББСБ” ХК-ийн зээл, 930.0 сая төгрөг нь хүүгийн авлага байна.

Багц худалдан авсан болон үндсэн зээлийн төлбөр, хүү болон нэмэгдсэн хүүгийн орлого нь нийт 16,536.9 сая төгрөг байгаагийн багц худалдан авсан төлбөр 18.2 сая төгрөг, буцаан шилжүүлсэн зээлийн үндсэн төлбөр 194.3 сая төгрөг, тайлант сард төлөгдсөн нийт үндсэн зээлийн төлөлт 10,884.1 сая төгрөг, үндсэн хүүгийн төлөлт 5,003.6 сая төгрөг, нэмэгдүүлсэн хүүгийн төлөлт 4.9 сая төгрөг, буцаан шилжүүлсэн үндсэн зээлийн өр болон зээлийн хуримтлагдсан хүүгийн орлого 241.0 сая төгрөг,

мөнгөөр төлөгдөөгүй ХБҮЦ буцаалт 190.8 сая төгрөг байна. “Инвескор ББСБ” ХК-д 10-р сарын ХБҮЦ-ны багцын төлбөрт 8,598.1 сая төгрөг, нэмж бүртгэсэн зээлийн үндсэн төлбөрийн дүн 1,964.7 сая төгрөг, хадгаламж, андеррайтерын үйлчилгээний хөлсөнд 1,124.0 сая төгрөг, хуримтлагдсан хүүгийн төлбөрт 850.4 сая төгрөг, 2024 оны 10-р сарын 9-ний өдрийн 2024/Н-01 дугаар бүхий хөрөнгийн багцыг нэмэгдүүлэх актын дагуу 101.4 сая төгрөг, үйлчилгээний төлбөр болон нотариатын төлбөрт 238.5 сая төгрөгийн тус тус зарцуулсан байна. Дээрх орлого, зарлагын зөрүү 3,660.0 сая төгрөг байна.

Үндсэн болон хуримтлагдсан хүүгийн орлого нь 5,607.2 сая төгрөг, мөн үндсэн болон хуримтлагдсан хүүгээс төлөгдсөн 4,677.1 сая төгрөг байна. Дээрх орлого зарлагын зөрүү 930.0 сая төгрөг байна.

3.4. Татварын өр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ААНОАТ-ын өр	-	118,625,016.85
ХХОАТ-ын өр	-	334,115.16
Бусдаас суутгасан татварын өр	-	105,958,904.13
Нийт дүн	-	224,918,036.14

Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т заасны дагуу 118.6 сая төгрөгийг тооцож олгосон байна.

“Инвескор Эй Би Эс” ХХК-ийн 2024 оны 4-р сарын 19-ний өдрийн 02 дугаар бүхий хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэрээр компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Тэдгээрт 3.8 сая төгрөгийн цалин олгож, цалингаас 0.3 сая төгрөгийг хувь хүний орлогын албан татварыг тайлагнажээ.

Татварын суутган тооцооллоор нийт 106.0 сая төгрөгийг 2025 оны 1-р сарын 8-ны өдөр төлж барагдуулсан байна.

3.5. Хүүгийн өглөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Зээлийн хүүгийн өглөг	-	628,754,523.30
Нийт дүн	-	628,754,523.30

628.8 сая төгрөгийг зээлийн хүүгийн өглөгөөр бүртгэж тайлагнасан байна.

3.6. Бусад богино хугацаат өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Бусад богино хугацаат өр төлбөр	-	24,295,987,777.67
Хорогдуулалт	-	(64,001,111.00)
Нийт дүн	-	24,231,986,666.67

3.7. Бусад урт хугацаат өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Бусад урт хугацаат өр төлбөр	-	25,832,014,444.34
Хорогдуулалт	-	(960,016,666.67)
Нийт дүн	-	24,871,997,777.67

Үүсгэн байгуулагч “Инвескор ББСБ” ХК, үнэт цаас гаргагч “Инвескор Эй Би Эс ТЗК” ХХК-ний хооронд 2024 оны 6-р сарын 18-ны өдөр АҮГ-240618/01 тоот Андеррайтерийн үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулжээ. Гэрээний 1.2-т “Үнэт цаас гаргагч нь нийт 50,000.0 сая төгрөгийн үнийн дүн ХБҮЦ-ыг гарган, хөрөнгийн зах зээлд нээлттэй арилжаалах замаар санхүүжилт татах үйл ажиллагаанд “Инвескор Капитал ҮЦК” ХХК-ийг андеррайтероор сонгосон болно”, 1.3-т “Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах нийт 50,000.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий, нэг бүр нь 100.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 18 сарын хугацаатай, жилийн 17 хувийн хүүтэйгээр ХБҮЦ-ыг хөрөнгө оруулагчдад санал болгоно” гэжээ.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ний 2024 оны 8-р сарын 12-ны өдрийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэх тухай” А/334 дүгээр тоот тушаалаар “Инвескор Эй Би Эс ТЗК” ХХК-ний гаргаж буй 18 сарын хугацаатай, жилийн 17 хувийн хүүтэй нэг бүр нь 100,000.00 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 500,000 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ний үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн байна.

“ҮЦТХТ” ХХК, “Инвескор Эй Би Эс ТЗК” ХХК-ийн хооронд 2024 оны 8-р сарын 21-ний өдөр “Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ”-гээ байгуулжээ. Гэрээний 2-т дээрх тушаал, гэрээнд заасантай адил үнэт цаасны гаргасан тоо, нэрлэсэн үнэ, үнийн дүн, хугацаа, хүү тусгасны зэрэгцээ, үнэт цаасны хүү төлөгдөх давтамж улирал бүр, үнэт цаасны дуусах хугацааг 2026 оны 2-р сар, үнэт цаасны эргэн төлөлт 12 дах сар 50 хувь, 18 дах сард үлдэгдэл 50 хувь байхаар, “Инвескор ХБҮЦ”-ыг хадгалуулахдаа үнэт цаасны нийт үнийн дүнгээс 0.045 хувьтай тэнцэх хэмжээний үйлчилгээний хөлс төлөхөөр гэрээнд тусгасан байна.

3.8. Хувьцаат капитал

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Энгийн хувьцаа - Хувьцаа эзэмшигч “Инвескор ББСБ” ХК	10,000,000.00	10,000,000.00
Нийт дүн	10,000,000.00	10,000,000.00

Улсын бүртгэлийн гэрчилгээнд хувь нийлүүлсэн хөрөнгийг 10,000.0 мянган төгрөгөөр бүртгүүлсэн байна. Мөн компанийн дүрэмд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэг бүрийн нэрлэсэн үнэ 100,000.0 төгрөгийн 100 ширхэг энгийн хувьцаа бүхий 10,000,000.0 төгрөгөөс бүрдэнэ гэж тусгасан байна.

3.9. Хүүгийн орлого

Үзүүлэлт	2024.06.31	2024.12.31
Хүүгийн орлого	-	5,185,332,236.96
Нийт дүн	-	5,185,332,236.96

Тайлант онд хүүгийн орлогоор нийт 10,288.6 сая төгрөг олж, хүүгээс төлөгдсөн 5,103.3 сая төгрөгийг үүсгэн байгуулагч “Инвескор ББСБ” ХК-д олгожээ.

3.10. Ерөнхий ба удирдлагын зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үйлчилгээний зардал	-	26,130,000.00
Цалингийн зардал	-	3,766,800.00
НДШ-ийн зардал	-	452,016.00
Мэргэжлийн үйлчилгээний зардал	-	538,177,298.92
Нийт дүн	-	568,526,114.92

Тайлант хугацаанд ерөнхий ба удирдлагын зардалд 568.5 сая төгрөгийн зардал гаргасан байна. Нийт зардлын 94.7 хувь буюу 538.2 сая төгрөг нь мэргэжлийн үйлчилгээний зардал, 4.6 хувь буюу 26.1 сая төгрөг нь үйлчилгээний зардал, 0.7 хувь буюу 4.2 сая төгрөг нь цалин, НДШ-ийн зардал байна.

3.11. Санхүүгийн зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Хүүгийн зардал	-	2,747,945,205.48
Зээлийн эрсдэлийн зардал	-	680,167,803.84
Нийт дүн	-	3,428,113,009.32

Тайлант онд санхүүгийн зардалд 3,428.1 сая төгрөг, үүний дотор хүүгийн зардал 2,747.9 сая төгрөг, зээлийн эрсдэлийн зардал 680.2 сая төгрөг байна.

3.12. Орлогын татварын зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Орлогын татварын зардал	-	118,867,841.59
Нийт дүн	-	118,867,841.59

Тайлант хугацааны аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 118.9 сая төгрөг байна.

3.13. Холбоотой талуудын ажил гүйлгээ

Санхүүгийн тайлангийн зорилгоор талууд нь НББОУС 24 буюу “Холбоотой талын тодруулга”-д тодорхойлсноор хэрвээ тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол холбоотой талууд гэж тодорхойлно. Холбоотой талуудын магадлалыг авч үзэхдээ хуулийн хэлбэрээс илүү эдийн засгийн холбоо хамаарлыг авч үзнэ гэж заасны дагуу холбоотой талуудын мэдээллийг татварын тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулга хэсэгт тайлагнах үүрэгтэй.

3.14. Балансын дараах үйл явдал

2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр хүртэл "Инвескор Эй Би Эс ТЗК" ХХК-ийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулах шаардлагатай үйл явдал гараагүй байна.

Ахлах аудитор



Ш.Уянга

2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр